

**БАТЛАВ.
ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫНҮҮРЭГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЦЭНД**

**“АВТОБУСНЫ ЖОЛООЧИЙН АЖЛЫН ЦАМЦ, ХАНТААЗ ХИЙЛГЭХ” ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАХАД ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: АВТОБУСНЫ ЖОЛООЧИЙН АЖЛЫН ЦАМЦ, ХАНТААЗ ХИЙЛГЭХ
Төслийн дугаар: НЗТНОНӨААТҮГ/202007045**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[“Жолоочийн цамц хантааз хийлгэх НЗТНОНӨААТҮГ/202007045”**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 09 цаг]**-аас өмнө www.tender.gov.mn сайтаар тендерийн материал хүлээж авна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 10 дугаар сарын 08-ны 09 цаг 20 минут-д өөрийн байрны 206 тоот өрөөнд нээнэ**

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр, 2 давхар, 206 тоот өрөө],
Утас-11343169**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогчдын эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлоход дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ААНБ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. 2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ. 3. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим системээр дамжуулан шалгах болно. 4. Харьяа нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ. 5. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай. Тухайн хуулийн этгээдийн байнгын үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн шүүхийн тодорхойлолтыг ирүүлэх /иргэн болон захиргааны хэргийн шүүх/. Энэхүү тодорхойлолтоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд үнэлгээнд харгалзаж үзнэ. 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. 7. Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр, 2 давхар, 206 тоот өрөө.</p> <p>Захиалагчийг төлөөлж: Худалдан авах ажиллагааны мэргэжилтэнд Утас: 343169 Огноо: 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, 206 тоот өрөө. Огноо: 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Цаг: 09 цаг 20 минут</p>

ТӨӨЗ 3,1

Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.
2. Бараа нийлүүлэлтийн хувиарыг баталгаажуулан ирүүлнэ
3. Тендерт оролцогч нь тухайн барааны үнийн болон нийлүүлэлтийн хуваарийг батиалгаажуулан ирүүлэх ба ба нийт 30 хоногийн хугацаанд тус байгууллагын жолоочийн цамц, хантаазыг бүрэн хийж гүйцэтгэн нийлүүлэх үүрэг хүлээнэ. /бараа нийлүүлэх нарийвчилсан хугацааны хуваарилалтыг баталгаажуулан ирүүлэх/
4. Сүүлийн жилийн борлуулалтын орлого нь бараа нийлүүлэхээр санал болгосон үнийн дүнгийн 100% иас багагүй байх.
5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018,2019 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
6. Сүүлийн 2 жилийн /2018, 2019 онуудын аль нэгд/ туршлагын мэдээлэл /ижил төрлийн бараа нийлүүлж байсан гэрээ, барааг хүлээлгэн өгсөн комиссын актын хуулбараар нотлогдоно./
7. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга
8. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл /хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
9. Голлох болон туслах ажилтны ажил байдлын тодорхойлолтыг холбогдох диплом, мэргэжлийн үнэмлэх, сертификатын хамт
10. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байгаага албан бичгээр ирүүлнэ.
11. “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг хангасан барааг нийлүүлэхээ зөвшөөрч байгаа талаар албан бичиг ирүүлнэ.
12. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараандаа 1 жилийн чанарын баталгаа өгөх талаар албан мэдэгдэл өгөх. /Баталгаат хугацаа буюу нийлүүлснээс хойш 1 жилийн хугацаанд үйлвэрийн технологийн алдаанаас үүдэлтэй эвдэрч, гэмтэж, урагдаж, ханзрах тохиолдолд ажлын хувцсыг үнэ төлбөргүй засварлах эсхүл шинээр солих үүргийг нийлүүлэгч тал хариуцна./
13. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.
Уг ажлыг гүйцэтгэхэд ашиглагдаж буй материал түүхий эд болон тухайн ажлыг гүйцэтгэх менежмент нь Байгаль орчинд ээлтэй технологиор гүйцэтгэсэн бол мөн уг ажлыг гүйцэтгэхэд шинэ дэвшилтэт техник технологи ашигласан бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.
14. Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт болон фото зураг бүхий дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх
15. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараандаа 1 жилийн чанарын баталгаа өгөх талаар албан мэдэгдэл өгөх. /Баталгаат хугацаа буюу нийлүүлснээс хойш 1 жилийн хугацаанд үйлвэрийн технологийн алдаанаас үүдэлтэй эвдэрч, гэмтэж, урагдаж, ханзрах тохиолдолд ажлын хувцсыг үнэ төлбөргүй засварлах эсхүл шинээр солих үүргийг нийлүүлэгч тал хариуцна./
16. Ашигтай ажилласан байх жилийн тоо 2 /2018,2019/
Дээр заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.

ТӨӨЗ 6.2

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ***багцгүй***

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Зорилго: Байгууллагын нийт ажилтныг Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн холбогдох шаардлагыг бүрэн хангасан, чанартай нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (ажлын хувцас)-ээр хангах зорилготой.

Үндсэн шаардлага:

Уг барааг нийлүүлэх компани нь дараах шаардлагуудыг хангасан байна.

1. Техникийн тодорхойлолтод зааснаас өөрөөр хийгдсэн тохиолдолд шаардлагын дагуу дахин шинэчлэнэ.
2. Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид анх ирүүлсэн 1 ком загварын хувцаснаас сатериал, чанар /гараар мэдрэхэл ялгаагүй/, өнгө хийцийн хуьд ялгаагүй, өнгө зөрүүгүй адил байна. Ялгаа гарсан тохиолдолд Захиалагч ирүүлсэн хувцсыг бүгдийг Гүйцэтгэгчид бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаарлагад хангасан хувцсаар солиулна.
3. Бүх хувцас хэрэгсэлд орсон материал нь Монгол улсын холбогдох стандарт хангасан, хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлдэлгүй, мөн шатахад барьж наалддаггүй болохыг нотлох мэргэжлийн байгууллагын сертификат тодорхойлолттой байна.
4. Ажлын хувцасны бүх чимэг оёдлыг 1см-т 4-5 дотор холбогдох, хавсарсан оёдлыг 1см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын мяндсан утсаар оёно.
5. Ажлын хувцас хийх материалыг өмнө нь 100 С-т угаалганд оруулж эсгэх, оёх ажлыг хийж гүйцэтгэнэ.
6. Угаалга цэвэрлэгээний дараа агшиж (агшилт суналт нь анхны хэмжээний 5%-иас ихгүй) сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байх сайн чанарын материалаар хийгдсэн байна. (Угаалтаар агшиж сунасан тохиолдолд ажлын хувцсыг бүрэн солино).
7. Ажлын хувцсанд угаалга,арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлвэрлэгчийн нэр, арчилгааны заавар болон бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрт оёж тогтоосон байна.
8. Ажлын хувцас тус бүрт дугаарлалын тэмдэглэгээ бүхий давтагдашгүй хувийн дугаартай байна.

ХУВЦАС														
№	Хувцасны төрөл	Хувцасныхэмжээ /ширхэг/												ДҮН
		36	38	40	42	44	46	48	50	52	54	56	Хэмжээ авах	
4	Зуны хантааз					17	29	70	134	40	10			300
5	Дан цамц - жолооч					29	120	199	174	55	19	4		600
	НИЙТ ДҮН					46	149	269	308	95	29	4	6	900

Хантааз		
1	Захиалгын тоо	300
2	Улирал	Зун
3	Хүйс	Эр, эм
4	Өнгө	Үндсэн өнгө: Саарал, Оруулга: Улаан хүрэн
5	Материал	Салхи чөлөөтэй нэвтрүүлдэг, хөлс шингээдэг, хүний биед гаж нөлөө байхгүй, хөлс гарах үед харшил өгөхгүй, цахилгаанжихгүй, амархан бохирдохгүй, оёдол эдэлгээний явцад ханзрахгүй, өнгө алдахгүй, хөдөлгөөн хязгаарлахгүй, цэвэрлэхэд хялбар байна. Хөдөлгөөнд саад болохгүй торон, 65%-ийн хөвөндаавуу, 35%-ийн полестрол байна.
6	Үзүүлэлт	Хошуу захтай, арын болон энгэрийн дээд хэсгээр улаан хүрэн оруулагатай, энгэрт нэг, доороо хоёр нийт гурван тагтай, таг нь коноптой ил халаастай, зүүн энгэрт таггүй, үзэг бал хийх жижиг тасалгаа бүхий ил халаастай, ил 4 халаас нь давхар гоёлын оёдолтой, бүсэлхийгээр цахилгаан бүхий хоёр далд халаастай байна. Зүүн энгэрт байгууллагын хатгамал логотой, үндсэн өнгийн материалаар ханцуйний ухлаадас, энгэр, хормойг бүрэн эмжсэн байх, арын хэсэг нь улаан хүрэн оруулганаас доош торон, салхи нэвтрэх материалтай байна.



Жолоочийн цамц		
1	Захиалгын тоо	600
2	Улирал	Хавар, намар
3	Хүйс	Хамаарахгүй
4	Өнгө	Үндсэн өнгө: Цэнхэр, Оруулга: Улаан хүрэн
5	Материал	Салхи чөлөөтэй нэвтрүүлдэг, хөлс шингээдэг, хүний биед гаж нөлөө байхгүй, хөлс гарах үед харшил өгөхгүй, цахилгаанжихгүй, амархан бохирдохгүй, оёдол эдэлгээний явцад ханзрахгүй, өнгө алдахгүй, хөдөлгөөн хязгаарлахгүй, цэвэрлэхэд хялбар байна. Хөдөлгөөнд саад болохгүй 65%-ийн хөвөн даавуу, 35%-ийн полестрол байна.
6	Үзүүлэлт	Сорочкон захтай, арын болон энгэрийн дээд хэсгээр улаан хүрэн оруулагатай, энгэртээ болон доороо тус бүр хоёр, нийт дөрвөн ил, тагтай халаастай, энгэр нь цахилгаан товчтой, түүнийг таглаж оёсон урт хаалттай, хаалт нь кнопон товчтой. Бугуй хэсгээр томосгож багасгах тохируулгатай, зүүн энгэрт байгууллагын хатгамал логотой.



2. Стандарт: Уг бараа нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.
3. Баглаа, боодол: Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын агуулах.
4. Бараа хүргэх газар: [Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын агуулах
- 5.

1. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Д/д	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Жолоочийн хантааз	300	ширхэг	ЗТН-ийн агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор	
2	Жолоочийн цамц	600	ширхэг	ЗТН-ийн агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2019.00.00]

(Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ)-ын дарга Г.Төмөрбаатар танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
бусад.				

МАЯГТ

ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____ компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул _____ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ нь _____ компанийг төлөөлж _____ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 20__ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр гарын үсэг зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн

Овог, нэр _____
Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн

Овог, нэр _____
Гарын үсэг _____

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Захиалагч тал хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ажлын хувцсыг бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу гэрээнд заасан хугацаанд техникийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг нэг бүрчлэн газар дээр нь шалгаж хүлээн авна. Хэрэв шаардлага хангахгүй, хэмжээ зөрсөн ажлын хувцас гарсан тохиолдолд засварлах болон шинээр солих арга хэмжээ авах бөгөөд ажлын 5 хоногийн дотор багтаан шийдвэрлэнэ. Холбогдон гарах зардлыг нийлүүлэгч тал хариуцна. Байгууллагын ХАБЭААХА-ны ажилтан шалгаж нярав хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

Батлагаат засварын хугацаа хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ажлын хувцсыг хүлээн авснаас хойш 1 жил байна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Ажлын хувцасыг нийлүүлсэн тоо хэмжээгээр акт үйлдэн хүлээн авсны дараа нийлүүлэгч талын нэхэмжлэхийг үндэслэн захиалагчийн дансанд шилжүүлнэ. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: [0.5]

Алдангийн нийт дүн: [10 хувь] |

¹ Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтоногдуулахалдангигэрээнийүнийн алдангийннийтдүнгэрээнийүнийндүнгийн 10 хувиастустухэтрэхгүй.

0.5 хувиас,

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭТГЭЛ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЦЭНД

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

“АВТОБУСНЫ ЖОЛООЧИЙН АЖЛЫН ЦАМЦ ХАНТААЗ ХУДАЛДАН АВАХ” ГЭРЭЭ
Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Улаанбаатар хот

Нэг талаас [Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

³ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]